

БАТЛАВ  
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ДАВРЫН ДАРГА

2024 оны 3 дугаар сарын ... өдөр

## АШИГЛАЛТЫН ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ ХУУЧИН ТӨР ЗАХИРГААНЫ БАЙРЫГ БУУЛГАЖ ТОХИЖИЛТ ХИЙХ АЖЛЫН ЗУРГИЙН ДААЛГАВАР

2024 оны 3 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

1.	Төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none"><li>- Нийслэлийн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 3 дугаар тогтоол.</li><li>- Хот байгуулалт хөгжлийн газрын 2024 оны МЗХ2024/00-076 дугаартай тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар.</li></ul>
2.	Байршил, эдэлбэр газрын хэмжээ, Зориулалт, хүчин чадал	<ul style="list-style-type: none"><li>- Хан-Уул дүүргийн 20 дугаар хороо, Иргэдэд үйлчлэх төв байрны урд талын хуучин төр захиргааны байр.</li><li>- 2668,87 м.кв талбай.</li></ul>
3.	Одоогийн байдал	<ul style="list-style-type: none"><li>- Ашиглалтын хугацаа дуусаж хуучирч муудсан.</li></ul>
4.	Төсөл гүйцэтгэх хугацаа	<ul style="list-style-type: none"><li>- Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.</li></ul>
5.	Төслийн захиалагч	<ul style="list-style-type: none"><li>- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар.</li></ul>
6.	Төсөл гүйцэтгэх үе шат	<p><b>Буулгалтын ажил</b></p> <ul style="list-style-type: none"><li>- Буулгалтын зураг төсөв боловсруулах.</li><li>- Төсөвт магадлал хийлгүүлсэн байх.</li><li>- Батлагдсан төсөв, ажлын тоо хэмжээгээр барилга буулгалтын ажлыг гүйцэтгэх.</li><li>- Буулгалтын ажил хийгдсэний дараах барилгын хогийг цэвэрлэж, зам талбайг нөхөн сэргээх.</li></ul> <p><b>Зураг төсөв боловсруулах</b></p> <ul style="list-style-type: none"><li>- Талбайн судалгаа, хэмжилт.</li><li>- Эдэлбэр газарт газрын зураглалын тодруулалт хийлгэх, газар доорх болон дээрх шугам сүлжээг тодруулах.</li><li>- Тухайлсан байршилд инженер геологийн дүгнэлтийг гаргуулж баталгаажуулах.</li><li>- Загвар зураг болон ажлын зураг төсөв боловсруулан мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцөн батлуулах.</li><li>- Холбогдох норм, дүрэм, стандартын дагуу төлөвлөх.</li><li>- Төслийн талбайд инженерийн шугам сүлжээ илэрвэл зөөх, шилжүүлэх техникийн нөхцөл гаргуулах бөгөөд тухайн шугам зөөх шилжүүлэх ажлын зураг болон зардал, авто зам, явган талбайн нөхөн сэргээлтийн зардлыг төсөвт тусгаж мэргэжлийн байгууллагатай зөвшилцөн баталгаажуулах.</li><li>- Зураг төслийг боловсруулахад үерийн хамгаалалтын далан, суваг шуудуу, ус зайлуулах шугам сүлжээг анхаарч төлөвлөх.</li><li>- Батлагдсан зургийн дагуу төсөв боловсруулах.</li><li>- Магадлал хийлгүүлэх.</li></ul> <p><b>Тохижилтын ажил</b></p> <ul style="list-style-type: none"><li>- Батлагдсан зураг төсвийн дагуу тохижилтын ажлыг хийж гүйцэтгэх.</li></ul>
7.	Төслийн иж бүрдэл	<ul style="list-style-type: none"><li>- Батлагдсан төсвийн дагуу буулгалтын ажлыг гүйцэтгэсэн тухай акт.</li><li>- Өмнөх болон дараах байдлын фото зураг.</li><li>- Хог хаягдлыг буулгасан тухай баримт бичгүүд хавсаргах.</li><li>- /БХБ-ын сайдын 2020 оны 48 дугаар тушаалаар батлагдсан</li></ul>

		<p>“Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах” журмын дагуу бүрдүүлэх/</p> <ul style="list-style-type: none"> <li>- Геодизийн ажлын тайлан.</li> <li>- Инженер геологийн судалгааны ажлын тайлан.</li> <li>- Батлагдсан зураг төсөл.</li> </ul>
8.	Орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>- Архитектур орон зай төлөвлөлтийг тус байршлын онцлог, шаардлага, орц гарц, орчны ерөнхий төлөвлөгөөтэй тохижилтын шийдэл гаргах.</li> </ul> <p><b>Ногоон байгууламж:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Одоо байгаа мод, бут, сөөгийг гэмтээхгүй шинээр Монгол орны уур амьсгалд тохирсон шилмүүст болон навчит мод, бут, сөөг, зүлэг тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлэх.</li> <li>- Ногоон байгууламжийг хамгаалсан хайс төлөвлөх. (модон шонтой)</li> </ul> <p><b>Явган зам, талбай:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Зорчигчдын амрах талбай болон хүний хөдөлгөөнийг салгаж зорчигчдын хөдөлгөөнийг сайжруулах орц гарцыг нэмэгдүүлж төлөвлөх.</li> <li>- Явган хүн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056:2009 стандарт.</li> <li>- Явган хүний зам, талбайн төлөвлөл, хучилт, угсралтад тавигдах шаардлага UCS 0901B:2022 стандартыг нийцүүлэн төлөвлөх.</li> </ul> <p><b>Авто зогсоол</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийт талбайн 70 хүртэл хувьд авто зогсоол төлөвлөх</li> <li>- Авто замын явах хэсэг, тээврийн хэрэгслийн зогсоол, тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу төлөвлөх.</li> <li>- Авто зогсоолын /БНБД 21-5-10/, автомашины ангилал, ерөнхий шаардлага, Монгол улсын стандарт “MNS:5342:2003”-д нийцүүлж төлөвлөх.</li> </ul> <p><b>Бусад</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Унадаг дугуйн зогсоол төлөвлөх.</li> <li>- Сандал болон саравч сүүдрэвчид тавигдах ерөнхий шаардлага UCS 1404B:2022 стандартыг нийцүүлэн төлөвлөх.</li> <li>- Гадна гэрэлтүүлгийг орчин үеийн загвартай эрчим хүчинд хэмнэлтэй гэрэлтүүлэг шинээр төлөвлөх. Хан-Уул дүүргийн Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ-тай зөвшилцөн гэрэлтүүлгийн тэжээл авах.</li> <li>- Хяналтын камер, тамхины цэг, хүний анхан шатны хэрэгцээ болох цэвэр усны цорго төлөвлөх.</li> </ul>
9.	Төслийн захиалагч	<ul style="list-style-type: none"> <li>- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар.</li> </ul>
10.	Ажил гүйцэтгэхэд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>- Буулгалтын ажлыг гүйцэтгэхдээ ил далд ажлын актыг үйлдэж фото зургаар тухай бүр баталгаажуулж байх.</li> <li>- Буулгалтын ажлыг гүйцэтгэхдээ бусад аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд саад учруулахгүй, орц гарцыг чөлөөтэй байхаар тооцон хаалт, хашаа болон анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу байрлуулах шаардлагатай.</li> <li>- Гадна инженерийн шугам сүлжээг зөөж шилжүүлэхдээ холбогдох норм дүрэм мөрдөх.</li> <li>- Ойролцоо барилгуудын инженерийн шугам сүлжээнд гэмтэл учруулахгүй байх арга хэмжээ авах.</li> <li>- Мод, бут, сөөг, шонгийн мод, гадна шугам сүлжээг буулгах зэрэг ажлыг санал болгож буй үнийн тооцон төсөв ирүүлэх.</li> <li>- Гүйцэтгэгч байгууллага нь барилгыг буулгах ажлыг тус ажлын хүрээнд хамаарах “Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм”-ийг мөрдөж ажиллана.</li> <li>- Барилга байгууламжийг буулгах үйл ажиллагааны дүрэм БД 20-101-12 болон холбогдох бусад хууль, дүрмийг баримтлан ажиллана “Барилга захиалагчийн дүрэм”, “Дүүргийн хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн авах, хяналт тавих журам”-н дагуу захиалагчийн хяналтыг хэрэгжүүлнэ.</li> </ul>

11.	Төсөл боловсруулахад ашиглах материал	<u>Хууль тогтоомжууд:</u> <ul style="list-style-type: none"> <li>- Барилгын тухай хууль</li> <li>- Хот байгуулалтын тухай хууль</li> <li>- Эрчим хүчний тухай хууль</li> <li>- Хог хаягдлын тухай хууль</li> <li>- Бусад хуулиуд</li> </ul> <u>Норм, нормативууд:</u> <ul style="list-style-type: none"> <li>- Барилга захиалагчийн дүрэм</li> <li>- Дуу чимээ тусгаарлалт /БНБД 23-05-10/</li> <li>- Бетон ба төмөр бетон бүтээц. Ерөнхий журам /БНБД 52-01-10/</li> <li>- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм</li> <li>- Бусад холбогдох норм, дүрэм</li> </ul> <u>Стандартууд:</u> <ul style="list-style-type: none"> <li>- "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага" MNS 4990:2000</li> <li>- Бусад холбогдох стандартууд.</li> <li>- Улаанбаатар хотын "Нэг хот, Нэг стандарт"-ын эмхтгэл UCS стандартын холбогдох бусад баримт бичгийг мөрдөх.</li> </ul>
12.	Эдийн засгийн тооцоо, төсөв	- Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНБД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох.
13.	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага	- Гадаргуугийн ус зайлуулах шийдлийг орчны байгууламжуудтай уялдуулан нэгдсэн байдлаар иж бүрэн шийдвэрлэх.
14.	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>- Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавих ерөнхий шаардлага UCS 0902B стандартыг мөрдөх.</li> <li>- Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага UCS 0301B стандартыг мөрдөх.</li> <li>- Улаанбаатар хотын "Нэг хот, Нэг стандарт"-ын эмхэтгэл болох UCS стандартуудыг мөрдөж ажиллах</li> </ul>

ХЯНАСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Л.ОТГОНБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.МӨНГӨНШАГАЙ

ТОХИЖИЛТЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ДААЛГАВАР

2024 оны 03 сарын 11 өдөр

Дугаар:МЗХ2024/00-076

АТЗ 6940  
9077243

Улаанбаатар хот

1	Төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none"> <li>- Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 75 дугаар тушаалаар баталсан Нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах үйл ажиллагааны журам,</li> <li>- Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 14 дугаартай "Барилга акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тухай" тогтоол,</li> <li>- "2024 оныг "Тохижилт-Бүтээн байгуулалтын жил болгон зарлах тухай" Нийслэлийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр захирамж,</li> <li>- Хан-уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 03 дугаар сарын 1-ний өдрийн 03/365 дугаартай албан бичиг,</li> <li>- Хан-уул дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт, 1700800285 нэгж талбарын дугаартай 5671 м<sup>2</sup> газар.</li> </ul>
2	Тохижилтын ажлын нэр /төрөл/ байршил	Гадна талбайн тохижилт; Хан-уул дүүргийн 20 дугаар хороо /41 дүгээр цэцэрлэгийн хойд талд /
3	Тохижилт хийх газрын хэмжээ /Зориулалт/	2368.87 м <sup>2</sup> /1700800285 нэгж талбарын дугаартай эдэлбэр газарт/
4	Төслийн захиалагч	Хан-уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
5	Төсөл гүйцэтгэх хугацаа	Захиалагч гүйцэтгэгч талуудын байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
6	Төсөл боловсруулах үе шат	Төслийг хоёр үе шаттай боловсруулна. -Судалгаа, загвар зураг (2 хувь А4, А3 хэмжээтэй, CD) -Ажлын зураг
7	Төлөвлөлтийн орон зайд тавигдах шаардлага	<p>-Архитектур орон зайн төлөвлөлтийг Нийслэл хотын онцлог, шаардлага, орц гарц, орчны батлагдсан ерөнхий төлөвлөгөө, төсөл хөтөлбөр, тохижилтын төлөвлөлтийн шийдэлтэй уялдуулан, холбогдох хууль, норм ба дүрмийг мөрдлөг болгох.</p> <p><b>Явган зам талбай:</b></p> <p>-Хот байгуулалтын тухай хууль 12.6.1. /гудамж, замын сүлжээг тээврийн хэрэгсэл, дугуйтай ба явган зорчигчийн хөдөлгөөн, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, орон зайн зохиомж, орчны барилга байгууламжийн байршил, уран барилгатай нь уялдуулан, тасралтгүй өсөн хөгжих хөдөлгөөнтэй нэгдсэн систем байх/-ийг мөрдөх.</p> <p>-“Явган хүн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS6056:2009-стандарт, “Тахир дутуу хүнд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль” /БД 31-101-04/, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шаардлага хангасан зураг төсөл зохиох заавар” /БД 31-112-11/ норм стандартын шаардлага хангасан замын өргөн орон зайтай байна.</p> <p>-Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавигдах шаардлага (UCS 0901B:2022)-д нийцүүлэн төлөвлөх.</p> <p><b>Унадаг дугуйн зогсоол:</b></p> <p>-Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилт /БНБД 30-01-04/-ийг баримтлан Унадаг дугуйн замыг төлөвлөхөд тавих ерөнхий шаардлага /MNS 5683:2016/ болон унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавигдах шаардлага /UCS 0903B:2022/-д нийцүүлэн төлөвлөх.</p> <p><b>Хүүхдийн тоглоомын талбай:</b></p> <p>Хүүхдийн тоглоомын талбайг төлөвлөхөд тавих ерөнхий шаардлага /UCS 1405B:2022/-д нийцүүлэн төлөвлөх.</p> <p><b>Авто зам, зогсоол:</b></p>

НИЙСЛЭЛИЙН АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБАН

2024 оны 03 сарын 11 өдөр

-Авто зам, зогсоолыг барьж байгуулахдаа Нийслэлийн Замын хөгжлийн газартай зөвшилцөх.

-Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөхдөө тухайн орчмын ерөнхий төлөвлөлттэй уялдуулан Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавигдах ерөнхий шаардлага /UCS 0902B:2022/-д нийцүүлэн төлөвлөх.

**Ногоон байгууламж:**

-Ногоон байгууламж болон зүлэгжүүлэн тохижуулах талбай, зурвас байршил хэмжээ, нутаг дэвсгэрийн онцлог нөхцөл, үйл ажиллагааны чиглэл зориулалтад тохируулан тогтоох.

-Төлөвлөлтийг хийхдээ Хот суурин газрын цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн төлөвлөлтийн шаардлага /UCS 0801A:2022/-д нийцүүлэх.

-Байгалийн ландшафтын онцлог ба экологийн систем түүний аюулгүй байдал, тэнцвэртэй байдлыг хадгалан хамгаалах, сэргээх, арчлах, шаардлагатай тохиолдолд хуучин байсан ургамал, мод сөөг зэргийг өөр байршилд шилжүүлэхийг зөвшөөрнө.

-Мод, сөөг, ургамлын төрөл зүйлийн сонголтыг Мод, таримал ургамлын төрөл зүйлийн лавлах /UCS 0803B:2022/-ийг судлан байршиж буй бүс нутгийн уур амьсгалын нөхцөл, цэцэрлэгжүүлэлтийн зориулалт, нар, салхины нөлөөлөл, агаарын бохирдолт, хөрсний нөхцөл ургамлан нөмрөгийн байдалд тохируулж, тэдгээрийн өнгө, титмийн хэлбэрийг оновчтой сонгон төлөвлөх.

**Хашаа хайс:**

-Нийслэлийн нутаг дэвсгэрт хашаа, хайс, барих, ашиглах, буулгах журмыг баримтлах.

-Хашаа, хайс, хашлагад тавигдах ерөнхий шаардлага, хэрэглээ / UCS 1410B:2022/-д нийцсэн байх.

-Хашааны өнгө, загвар, өндөр зэргийг дээрх стандартын дагуу төлөвлөж загвар зурагт гудамжны дэлгээс зургаар харуулах

**Гэрэл, гэрэлтүүлэг:**

-Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг /БНБД 23-02-08/, Гэрэлтүүлэг чимэглэлийн ажлын хөдөлмөр зарцуулалтын жишиг /БНБД 83-27-00/ баримтлан Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд байршуулах гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавигдах шаардлага /UCS 1901B:2022/-д нийцүүлэн төлөвлөх.

-Гэрэлтүүлэг нь аюулгүй орчныг бүрдүүлэх, оновчтой байршилтай, эдийн засгийн үр ашигтай, эрчим хүчний хэмнэлттэй, нарны эрчим хүчийг ашигласан эко байхаар төлөвлөх.

-Мэргэжлийн хяналтаар баталгаажсан олон улсын шаардлагад нийцсэн дизайн загвар нь орчны тохижилтод нийцсэн сайн чанарын гэрэл төлөвлөх.

-Тохижилтын талбайг гэрэлтүүлэх хангамжийн бие даасан сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс хангагдах хэсгийн мэдээлэл, эх үүсвэрийн хүчин чадал, ачаалал зэргийг тооцож төлөвлөх.

**Сандал:**

-Нийтийн гудамж зам талбайд байршуулах сандалд тавигдах шаардлага /UCS 1404B:2022/-д нийцүүлэн төлөвлөх.

**Саравч, сүүдрэвч:**

-Саравч, сүүдрэвчид тавигдах ерөнхий шаардлага / UCS 1402B:2022/-д нийцүүлэн төлөвлөх.

**Хогийн сав:**

- Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байршуулах хогийн саванд тавигдах шаардлага / UCS 1403B:2022/-д нийцүүлэн төлөвлөх.

		<p><b>Бусад:</b></p> <p>-Мэргэжлийн хяналтаар баталгаажсан сайн чанарын тоног төхөөрөмж тавьж, Олон улсын стандартад нийцсэн хэмжээтэй төлөвлөх.</p> <p>-Хяналтын камер, тамхины цэг, хүний анхан шатны хэрэгцээ болох цэвэр ус уух цорго төлөвлөх.</p>
8	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага	<p>- Эдэлбэр газарт газрын зураглалын тодруулалт хийлгэх, газар доорх болон дээрх шугам сүлжээг тодруулсны үндсэн дээр зураг төслийг боловсруулах, инженерийн шугам сүлжээний засвар, арчлалтын арга хэмжээтэй уялдсан төлөвлөлтийн шийдлийг сонгох</p> <p>- Гадаргуугийн ус зайлуулах арга хэмжээг орчны байгууламжуудтай нэгдсэн байдлаар иж бүрэн шийдвэрлэх</p>
9	Төслийн иж бүрдэл	<p><b>Зургийн иж бүрдэл:</b></p> <p><u>Зурган мэдээлэл, судалгаа</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Одоогийн байдал, судалгааны танилцуулга</li> <li>- Байршлын схем М1:10000</li> <li>- Орчны тойм М1:5000</li> <li>- Байрзүйн дэвсгэр зураг М1:500</li> <li>- Одоогийн байгаа явган зам, талбай, автозамын сүлжээ М1:1000</li> <li>- Одоогийн ногоон байгууламжийн байгуулалт /Дендрологийн байгуулалт/</li> </ul> <p><u>Төлөвлөлтийн зураг</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Нүүр хуудас /Батлагдах хуудас/</li> <li>- Төлөвлөлтийн танилцуулга /Архитекторын шийдэл/</li> <li>- Гудамж замын сүлжээ М1:1000</li> <li>- Ерөнхий төлөвлөгөө М1:1000 /Батлагдах хуудас/</li> <li>- Хөдөлгөөний схем М1:2000</li> <li>- Явган зам, авто зам талбайн байгуулалт</li> <li>- Гэрэлтүүлгийн байгуулалт</li> <li>- Харагдах байдал /Төлөвлөлтийн орчинд эвлүүлсэн зураглал/</li> <li>- Дендрологийн байгуулалт</li> <li>- Дендрологийн шилжүүлсэн байгуулалт</li> <li>- Өндөржилт М1:1000</li> <li>- Улаан шугам М1:5003</li> <li>- Ус зайлуулах сувгийн зураг М1:1000</li> <li>- Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвас М1:1000</li> <li>- Хог, хаягдалын төвлөрүүлж, тээвэрлэх, зөөвөрлөх цэгийн схем М1:2000</li> </ul> <p><b>Зураг төсөлд стандарт масштабыг хэрэглэнэ.</b></p>
10	Онцгой нөхцөл	<p>-Төслийг боловсруулахдаа эзэмшил газар, төлөвлөгдсөн авто зам байгаа эсэхийг тухайн хариуцсан байгууллагуудаас авч хамтран ажиллах.</p> <p>-Зураг төслийн болон ажил гүйцэтгэх явцад тухайн нутаг дэвсгэрийн инженерийн шугам сүлжээний хариуцах байгууллагатай болон газар эзэмшигч холбогдох газруудтай зөвшилцөх.</p> <p>-Гудамжны зорчих хөдөлгөөний орц, гарцыг судалж оновчтой байдлаар төлөвлөх.</p>
11	Захиалагчийн нэр, утас	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, С.Энхбаяр; Утас: 77771965 ;

**Анхааруулга:**

1. Монгол Улсын хуулиуд, Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хууль, Газрын тухай хууль, Усны тухай хууль, Бусад холбогдох хуулиуд, бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүд, УИХ-ын 2013 оны 2-р сарын 08-ний 23 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын 2020 оны ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага"-ын баримт бичиг, Бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүд, Норм, дүрэм, Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30-01-04/, Хот, суурин хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар /УББ 11-202-00/, Барилгын орчны тохижилтын ажил /БНБД 3.01.06-90/, Бусад холбогдох норм, дүрмүүдийг баримтална.
2. Зураг төслийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага:


ЭРХНИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБАН

29 03 2020 ОНЫ 11 АДАГ



**ТОХИЖИЛТЫН АЖЛЫН СХЕМ ЗУРАГ**  
 МЗХ2024/00-076 дугаартай Тохижилтийн ажлын төлөвлөлтийн даалгаврын хавсралт

Байршил	Эзэмшигч	Зориулалт
Хан-Уул дүүргийн 20 дугаар хороо	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар	Гадна талбайн тохижилт



Масштаб 1:2000

Тусгаа: 1429571

(Архитектур төлөвлөлтийн даалгаврын хамт хүчинтэй.)

**ТАНИХ ТЭМДЭГ**

- Одоо байгаа барилга
- Төлөвлөлтийн хязгаарын хэмжээ
- Газрын хэмжээ
- Цэвэр усны шугам
- Болгорын шугам
- Дулааны шугам
- Холбооны шугам
- Үерийн шугам

**ТОДОРХОЙЛОЛТ**

1	Төлөвлөж буй байршил
2	Чингисийн өргөн чөлөө
3	Б.Шарвын гудамж
4	41 дүгээр цэцэрлэг
5	Хан-уул дүүргийн эрүүл мэндийн төв

**ОЛГОСОН ТАЛБАЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Эдэлбэр газар (м <sup>2</sup> )	-
ТОХИЖИЛТЫН ТАЛБАЙ (м <sup>2</sup> )	-2368.87

**ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙН СОЛБИЦОЛ**

№	X	Y	тал=урт(м)
1	641645.440	5306649.256	1-2=16.423
2	641629.017	5306649.168	2-3=6.980
3	641628.753	5306656.143	3-4=4.680
4	641624.073	5306656.143	4-5=10.889
5	641623.278	5306667.003	5-6=10.632
6	641612.683	5306666.120	6-7=2.207
7	641612.683	5306663.913	7-8=44.574
8	641568.271	5306660.116	8-9=33.221
9	641569.507	5306626.918	9-10=74.784
10	641644.204	5306630.538	10-11=4.059
11	641647.029	5306633.451	11-1=15.884



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
**ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР**  
 Хот төлөвлөлтийн хэлтэс

Хан-Уул дүүрэг, 23-р хороо, Арцатын ам /17100/  
 Наадамчдын зам 1200  
 Цахим хуудас: [www.uda.ub.gov.mn](http://www.uda.ub.gov.mn), [www.ebarilga.ub.gov.mn](http://www.ebarilga.ub.gov.mn)  
 Утас: 11-324975